

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Зөвшөөрлийн тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн
төслийн талаар

Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.2.2-ын "Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин" зорилтын 3.2.2.3-т "Шинэ аж ахуйн нэгжүүдийн зах зээлд нэвтрэхэд тулгардаг саад хоригийг арилгаж, гарааны компаниудын бизнесийг дэмжих экосистемийг бүрдүүлэх, зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, монополын эсрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ." гэж заасан.

Мөн Монгол Улсын сөрөн тэсвэрлэх чадавхийг нэмэгдүүлэхэд дотооддоо галт зэвсэг сум үйлдвэрлэх, угсрах, тэдгээрийн дэвшилтэд технологийг нутагшуулах, боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх, Монгол Улс үйлдвэрлэгч орон болох хэрэгцээ шаардлага үүссэн байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах иргэний чадавхи, орон нутгийн хамгаалалт, тэдгээрийн сургалт, бэлтгэлийн үйл ажиллагаанд зориулсан иргэний галт зэвсэг, сумны хүртээмжийг нэмэгдүүлэх, Зөвшөөрлийн тухай хууль болон салбарын суурь хуулийн хоорондын зөрчлийг арилгах, уялдааг сайжруулах практик шаардлага байна.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулалт, хамрах хүрээ

Зөвшөөрлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт нь хоёр зүйлтэй Монгол Улсад галт зэвсэг үйлдвэрлэх, угсрах үйл ажиллагааг хуулийн тодорхой зохицуулалттай болгох, Зөвшөөрлийн тухай хууль болон Галт зэвсгийн тухай хууль хоорондын зөрчлийг арилган, нийцлийг хангах зорилготой бөгөөд Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 11.1, 11.2 дахь заалтыг дараах байдлаар өөрчилнө.

Тусгай зөвшөөрөл (одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Зөвшөөрлийн хуулийн зохицуулалт)	Тусгай зөвшөөрөл (Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр хийгдэх өөрчлөлт)	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
11.1.иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг, сум, дагалдах хэрэгсэл, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох, худалдах	11.1. ан агнах, спорт сургалт, үзмэр цуглуулгын болон харуул хамгаалалтын зорилгоор галт зэвсэг, галт зэвсгийн үндсэн эд анги, дагалдах хэрэгсэл, галт хэрэгсэл, тусгай хэрэгсэл, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох, худалдах	Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
11.2.сум үйлдвэрлэх, дахин цэнэглэх	11.2.галт зэвсэг, сум үйлдвэрлэх, угсрах	Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар:

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсад үйлдвэрлэлийн шинэ чиглэл хөгжих бөгөөд Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхи, батлан хамгаалах үйл ажиллагаанд хувь нэмэр оруулах төдийгүй хууль хоорондын зөрчил арилж, иргэнд үүсэх хүнд суртал, ойлгомжгүй, тодорхойгүй нөхцөл байдал үгүй болно.

Хуулийн төсөл нь Н.Учрал нарын гишүүдийн өргөн барьсан Зөвшөөрлийн тухай болон дагаж өргөн барьсан хуулийн төслийн зарим хэсгийг сайжруулах, дутуу орхигдсон зарим зохицуулалтыг нөхнө.

---oOo---